
САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨР ЗАСГИЙН АМРАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР ТӨААТҮГ-ЫН 2018 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/70/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
	3.1 Өртөг зардалтай холбоотой асуудал	10
	3.1.1 Илрүүлэлт:	10
	3.1.2 Эрсдэл:	10
	3.1.3 Өгсөн зөвлөмж:	10
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	10
	3.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	11
	3.2.1 Илрүүлэлт:	11
	3.2.2 Эрсдэл:	11
	3.2.3 Өгсөн зөвлөмж:	11
	3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан:	13
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	16
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	17
5.	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨР ЗАСГИЙН АМРАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР
ТӨААТҮГ-ЫН ДАРГА Б.ТУУЛ
ТАНАА

2019.03.15 № 06/470
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр Засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төр Засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төр Засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төр Засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дарга Б.Туул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ноос 2019 оны 3 дугаар сарын 5-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-т хүргүүлэхээр төлөвлөн, “Б энд С аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах Б.Эрдэнэтогтох нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны 13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь экологийн цэвэр бүтээгдэхүүн, ур чадвартай манлайлагч хүний нөөц, тохилог орчноор мэргэжлийн өндөр зэрэглэлийн үйлчилгээг зохион байгуулагч, төр засгийн хоол, үйлчилгээний тэргүүлэх чиглэлийн байгууллага болох зорилттойгоор Төрийн ордны зоогийн газар, Элит төв, Горхи амралт гэсэн 3 салбараар төрийн 3 өндөрлөг, тэднээр дамжин ирсэн зочид төлөөлөгчид, УИХ-ын гишүүд, төрийн албан хаагч, ажилтнуудад үйлчилдэг мэргэшсэн хамт олон байх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын харьяа Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн ордны зоогийн газар
- Төрийн ордны зоогийн газрын буфет, кофе шоп
- Элит төв
- Горхи амралт

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай
- Татварын ерөнхий хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй” гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив” ХХК-ийн пирамид програм хангамж ашигладаг байна.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1 хувийг сонгов.

Энэ нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дансанд эрсдэл дунд гэж холбоотой юм.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,615.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 16.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь орлогын дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 13 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй 59.6 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт хэрэгжээгүй байна.
 - ✓ Шийдвэрлэсэн: Гэрээт борлуулагч нараас худалдан авсан бараа материалын анхан шатны баримтыг үдээгүй орхисоныг үдүүлж зөрчлийг арилгасан.
2. Хувь хүмүүсээс худалдан авсан бараа материал 125.7 сая төгрөгт ногдох татвар 12.6 сая төгрөгийг ХХОАТ-ийн ТТ-12-т тайлагнаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэхь заалттай нийцэхгүй байна.

- ✓ Шийдвэрлэсэн: Аудитын явцад татварт тайланг илгээж зөрчлийг арилгасан
- 3. Хангамжийн материал дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 294.2 сая төгрөг, бичиг хэрэг 1.2 сая төгрөг, авто машины сэлбэг хэрэгсэл 9.4 сая төгрөг нийт 304,832.4 мянган төгрөгийг данс бүртгэлд буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэхь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
 - ✓ Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн.
- 4. Шатахууны зардал 8.0 сая төгрөгийг бараа материалын дансаар бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн нь НББОУС-2, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалыг мөрдөж ажиллаагүй байна
 - ✓ Шийдвэрлэсэн: Аудитын явцад бараа материалын дансанд орлогод бүртгэж залруулга хийсэн.
- 5. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа НБББББ-ийг 2013 оноос хойш шинэчлэн боловсруулж ажиллаагүй байгаа нь НББОУС, СТОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 дахь заалтийг дагаж мөрдөөгүй байна.
 - ✓ Шийдвэрлэсэн: Аудитын явцад “Атланта баланс аудит” ХХК-тай гэрээ байгуулан НБББББ-ийг шинэчилж 2019 оны 3 дугаар сараас мөрдөн ажиллахаар байгууллагын даргын тушаал гарсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2		Хоол үйлдвэрлэлийн тайлан гаргаж, нэгж хоолны өртөг тооцоогүй, 2017 оны аудитын дүгнэлтийг шилэн дансны мэдээлэлд оруулаагүй
	Дүн	2		

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Элит” төвийн хоол үйлдвэрлэлийн орлогод ногдох НӨАТ-ыг харъяалах татварын байгууллагатай тооцоо хийж өр төлбөрийг барагдуулаагүй байна. Тухайн асуудлаар Татварын ерөнхий газарт 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 90 дугаар бичгээр хүсэлт гаргасан байна. Уг хүсэлтийн хариуг авч өр төлбөрийг хэрхэн барагдуулсан талаар дараагийн аудитаар нягтлан авч үзэх

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь 2018 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөнд орлого 1,529.0 сая, зардал 1,513.3 сая, ашиг 15.8 сая төгрөг байхаар төлөвлөж гүйцэтгэлээр орлого 1,615.9 сая, зардал 1,605.4 сая, ашиг 10.4 сая төгрөг байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ нь Шилэн дансны нэгдсэн системийн мэдээллийн самбарт 2018 онд нийт 103 мэдээлэл оруулахаас 40 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 51 мэдээллийг хугацаа хоцорч, 12 мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 99 хувьтай байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хэмжээг 91.6 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулаагүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Өртөг зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Хоол үйлдвэрлэлийн тайлан гаргаж, нэгж хоолны өртөг тооцож ажиллаагүй байна. Энэ нь НББОУС-2 бараа материал болон Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан тодруулга бэлдэх заавар”-ын 3 дугаар бүлгийн 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Өртөг зардал буруу тооцох

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Өртөг зардлыг тооцож холбогдох стандарт, хуулийг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар:

Цаашид өртөг зардлыг тооцож НБББББ-т тусган мөрдөн ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны вэб сайтад мэдээллийг хугацаа хоцроох буюу зарим мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1, 6.1.5-д заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Холдогдох хууль, тогтоомж зөрчигдөх, ил тод нээлттэй байдал алдагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид хуулийн хугацаанд батгаан мэдээллийг бүрэн гүйцэт байршуулж байх

3.2.4 Байгууллагаас ирсэн хариу тайлбар:

2019 оны 1 дүгээр улиралд залруулгыг хийж нөхөн байршуулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,144,465.71	7,827,147.12
1.1.2	Дансны авлага	900,000.00	700,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	195,339.00	211,325.16
1.1.6	Бараа материал	652,864,102.23	394,547,856.14
	Эргэлтийн хөрөнгийн дүн	666,103,906.94	403,286,328.42
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	128,179,901.54	600,516,944.82
1.2.2	Биет бус хөрөнгө	1,992,218.69	794,276,340.29
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	130,172,120.23	1,394,793,285.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	796,276,027.17	1,798,079,613.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	911,950.33	546,452.42
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	911,950.33	546,452.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	911,950.33	546,452.42
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	180,229,662.66	180,229,662.66
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	214,694,634.58	214,694,634.58
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,278,258.69	219,348,820.17
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,113,700.00	794,821,700.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	379,037,820.91	388,438,343.70
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	795,354,076.84	1,797,533,161.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	796,276,027.17	1,798,079,613.53

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,422,835,556.48	1,615,880,501.36
2	Борлуулалтын өртөг	580,846,027.01	816,147,623.30
3	Нийт ашиг(алдагдал)	841,989,529.47	799,732,878.06
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	662,719,488.42	625,417,046.71
10	Ерөнхий ба удирдлагын зардал	142,290,022.08	163,872,192.46
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	20,625,605.36	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-623.73	1,385.99
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,353,789.88	10,445,024.88
19	Орлогын татварын зардал	1,635,379.03	1,044,502.09
20	Татварын дараах ашиг (алдагдал)	14,718,410.85	9,400,522.79
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	14,718,410.85	9,400,522.79
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	14,718,410.85	9,400,522.79
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Уриимтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	364,319,410.06	780,635,665.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	364,319,410.06	780,635,665.99
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					14,718,410.85	14,718,410.85
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	379,037,820.91	795,354,076.84
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
11	Залруулсан үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	19,278,258.69	2,113,700.00	379,037,820.91	795,354,076.84
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					9,400,522.79	9,400,522.79
13	Бусад дэлгэрэнгүй орлого						
14	Өмчид гарсан өөрчлөлт			200,070,561.48	792,708,000.00		992,778,561.48
15	Зарласан ногдол ашиг						
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
17	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	180,229,662.66	214,694,634.58	219,348,820.17	794,821,700.00	388,438,343.70	1,797,533,161.11

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,399,645,704.48	1,643,020,921.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,396,874,899.48	1,630,445,421.36
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,770,805.00	12,575,500.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,397,899,384.46	1,647,339,625.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	415,629,963.00	414,473,078.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	85,400,000.00	100,700,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	704,319,417.50	966,295,354.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	98,177,410.00	72,655,267.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	67,090,049.00	45,271,894.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,313,428.70	14,720,000.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	218,740.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	16,750,376.26	33,224,032.94
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,746,320.02	4,318,704.58
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	494.47	1,605.89
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	494.47	1,605.89
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,534,958.20	219.90
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	1,533,840.00	
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	1,118.20	219.90
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,534,463.73	1,385.99
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	211,856.29	4,317,318.59
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,932,609.42	12,144,465.71
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,144,465.71	7,827,147.12

4.5 2018 оны төлөвлөгөө

Д/д	Санхүүгийн үзүүлэлтүүд	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	Зөрүү
1	Орлого	1,529,000,000.0	1,615,880,501.36	-86,880,501.36
2	Зардал	1,513,250,000.0	1,605,438,248.46	-92,186,862.47
3	Ашиг алдагдал	15,750,000.0	10,445,024.88	5,304,975.12

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Төр Засгийн Амралт Үйлчилгээний цогцолборын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.05			САГ-2019/70/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Төр Засгийн Амралт Үйлчилгээний цогцолбор		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Хоол үйлдвэрлэлийн тайлан гаргаж, нэгж хоолны өртөг тооцоогүй	0	Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн	Нягтлан бодогч	Б.Батжаргал
2	2017 оны аудитын дүгнэлтийг шилэн дансны мэдээлэлд оруулаагүй	0	Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн	Дарга нягтлан бодогч	Б.Туул Б.Батжаргал
	Дүн	0			

